






НИЙСЛЭЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ



НИИТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
/2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ/



УЛААНБААТАР ХОТ  
2022.07.01

## ГАРЧИГ

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН..... 5**

- 1.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ:.....5
- 1.2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ: .....8
- 1.3. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧТАЙ 2021-2024 ОНД ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ: .....15

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН..... 23**

- 2.1. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ: .....23

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН..... 24**

- 3.1. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ: .....24
  - 3.1.1. Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийн үйл ажиллагааны хүрээнд:.....24
  - 3.1.2. Судалгаа шинжилгээний ажлын хүрээнд: .....29
  - 3.1.3. Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд: .....41
  - 3.1.4. Сургуулийн сурагчдад зориулсан тээврийн үйлчилгээний шинэ менежментийг сайжруулах ажлын хүрээнд: .....44
  - 3.1.5. Нийтийн тээврийн бодлого, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах хүрээнд: ....45
  - 3.1.6. Холбогдох стандарт, шаардлага хангасан хүүхдийн болон ажилчдын автобусыг чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчуулах ажлын зохион байгуулах. ....53
  - 3.1.7. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм журмын хүрээнд шалгаж дүгнэлт гаргах, түвшин тогтоох аттестатчилал, сонгон шалгаруулалт явуулах ажлыг зохион байгуулах; .....54
  - 3.1.8. Нийслэлийн нийтийн тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах. ....54
  - 3.1.9. Ачаа тээвэр чиглэлийн хүрээнд:.....55
  - 3.1.10. Авто үйлчилгээний чиглэлийн хүрээнд: .....60

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ШИНЭ ТЕХНИК, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ НУТАГШУУЛАХ, САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:..... 66**

- 4.1. Нийслэлийн нийтийн тээврийн салбарт шинэ техник, технологийг нутагшуулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллах.....66
- 4.2. Дэвшилтэт техник, технологид суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, бүртгэлийн цогц үйлчилгээ, тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх. ....67
- 4.3. Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, програм

хангамжийг сайжруулах, системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох хэлтэс, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.....68

4.4 Нийтийн тээврийн удирдлагын төвийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах чиглэлээр төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран ажиллах. ....69

**ТАВДУГААР БҮЛЭГ. БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД: ..... 70**

5.1. Нийслэлийн нийтийн тээврийн тээврийн үйлчилгээ эрхлэгч болон ажилчдын, хүүхдийн автобустай аж ахуйн нэгж, байгууллагуудын стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл, жолоочийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэн шилжилт хөдөлгөөнийг холбогдох журмын дагуу хийх. ....70

5.2. Бүртгэлийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, тээврийн хэрэгслийн мэдээллийн талаар: .....70

5.3. Бүртгэлийн санд хийгдсэн өөрчлөлтийн талаар: .....71

5.4. Бүртгэлийн сангаас насжилтаар хасагдсан тээврийн хэрэгслийн тоо: .....73

5.5. Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн програм хангамжаас гарч буй мэдээлэл, өгөгдлийг нэгдсэн мэдээллийн санд байршуулах. ....74

5.6. Зорчигч тээврийн үйл ажиллагааг хангах зорилтын хүрээнд: .....75

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД: ..... 87**

6.1. Нийслэлийн нийтийн тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах чиглэлээр холбогдох сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, үр дүн, хэрэгжилтэд хяналт тавих; .....87

6.2. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-ын инженер техникийн ажилтнуудад “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны суурь ойлголт”сэдвээр сургалт зохион байгуулах; .....88

6.3. Нийтийн тээврийн салбарын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвлөгөө өгөх.....88

6.5. Нийслэлийн нийтийн тээврийн салбарын сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, салбарын хүний нөөцийг /инженер техникийн ажилчид болон жолооч/ мэргэжлийн түвшинд бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах сургалтыг төлөвлөгөөний дагуу холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; .....90

6.6. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарыг Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах, давтан сургах ажлыг холбогдох байгууллага, хэлтсүүдтэй хамтран төлөвлөгөө гарган зохион байгуулах; .....91

6.7. Авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл өгөх чиглэлээр .....92

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ(ЦААСАН БОЛОН ЦАХИМ)-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:..... 92**

7.1. Албан хэрэг, архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааврын хүрээнд хөтөлж, цахим тогтолцоог бүрдүүлэх;.....92

## НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаанд Монгол улсын болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газар болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар Зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т тусгагдсан зорилтуудыг, Автотээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журмын хүрээнд тус газраас хэрэгжүүлж ажиллалаа.

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тус газарт хамаарал бүхий 12 арга хэмжээний хэрэгжилт 55 хувь;

2. Зам, Тээврийн Хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын Зам, тээврийн салбарт 2020-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т туссан хамаарал бүхий 13 арга хэмжээний хэрэгжилт 59.23 хувь;

3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хамаарал бүхий 13 арга хэмжээний хэрэгжилт 55 хувь;

4. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн 20 арга хэмжээний хэрэгжилт 86,3 хувь;

5. Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт 100 хувь;

6. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2 хуралдаанаас өгсөн 8 үүрэг даалгавар, Нийслэлийн Засаг даргын 2 захирамжаар өгсөн 2 үүрэг даалгавар буюу нийт 10 үүрэг даалгаврын хэрэгжилт 100 хувьтайгаар тус тус үнэлэгдсэн бөгөөд бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу үнэлэн, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад тус тус хүргүүлсэн.

### **1.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ:**

**Тусгагдсан зорилт:** ЗГҮАХ-ийн 3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “3.6.3. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг цахилгаан болон байгалийн шатдаг хийгээр ажилладаг хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэлд бүрэн шилжүүлэн, цахилгаан болон байгалийн шатдаг хийгээр цэнэглэх сүлжээг бий болгоно” ажлын хүрээнд:

- ✦ Арга хэмжээ: Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлтийг хийнэ /900ш/

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Сүлдэрхэн минералд ХХК болон “Xia men golden dragon bus” Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) “Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн хүрээнд автобус нийлүүлэх ХААГ-21/015 дугаартай гэрээний дагуу 60 ширхэг их багтаамжийн автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг цахилгаан автобус, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Моннис Моторс” ХХК-тай байгуулсан 2020 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус нийт 91 автобусыг тус газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн А/51 дугаартай ажлын хэсэг хүлээн авч 2022 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар үйлчилгээнд ажиллуулж эхлээд байна.



*Парк шинэчлэлтээр орж ирсэн автобус*

Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Моннис Моторс” ХХК -тай байгуулсан 2020 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус Улаанбаатар хотод орж ирсэнтэй холбогдуулан Нийтийн тээврийн газрын даргын 2022 оны “Сургуулийн хүүхдийн автобус хүлээлцүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/41 дүгээр тушаалаар байгуулагдсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгөхөөр акт үйлдэн ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/190 дугаар захирамжаар Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх зорилтын хүрээнд цахилгаан хөдөлгүүртэй автобус нэвтрүүлэх тооцоо, судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт 2022 оны 03 дугаар сарын 03-ний өдөр 2/253, 2022 оны 04 дүгээр сарын 08-ний өдөр 2/387 дугаартай албан бичгүүдээр шаардлагатай тооцоо судалгааг хүргүүлсэн.

**Хэрэгжилтийн хувь: 90**

- ✦ Арга хэмжээ: Улаанбаатар хотын баруун зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлнэ.

-Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачааны логистик төв барих ажлын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг оновчтой зөв зохион байгуулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яам, Солонгос улсын логистик төлөвлөлтийг хийсэн Котро компани, Монгол дахь Солонгосын Элчин зэрэг байгууллагуудын хамтарсан “Монгол Улсын тээвэр, логистикийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратеги боловсруулах” техникийн туслалцааны төслийн онлайнаар зохион байгуулсан 3 шатны ажил хариуцсан мэргэжилтнүүдтэй хамт сургалтад хамрагдсан. Сургалтаар Солонгос улсын логистикийн загварыг ашиглан Улаанбаатар хотын логистик төлөвлөлт, ТЭЗҮ боловсруулахаар ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын 2020 оны А/1124 дугаартай захирамжаар “Налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журмын дагуу зохион байгуулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д үүрэг болгосон.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтсээс Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиглэл өгч бэлтгэл ажлын хүрээнд Сонгон шалгаруулалтын баримт бичгийн урьдчилсан загвар болон Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээний урьдчилсан загварыг боловсруулсан ба мэргэжлийн талуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, сонгон шалгаруулалтыг зарлаж, Туушин ХХК шалгараад байна.

“Нийслэл хотод ачаа тээврийн логистикийн төвд тавигдах стандарт”-ийг боловсруулж, хамтран ажиллах тухай 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 4/696 дугаартай албан бичгийг Хотын стандартын хяналтын газарт хүргүүлсэн.

#### **Хэрэгжилтийн хувь: 30**

**Тусгагдсан зорилт:** 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “6.1.5 Нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан ухаалаг, эко, цахилгаан хөдөлгүүрт дан болон давхар автобус, цахилгаан соронзон болон дүүжин замын тээврийн хэрэгслийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлнэ.” ажлын хүрээнд:

- ✚ Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглолтой тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Сүлдэрхан минералс ХХК болон “Xia men golden dragon bus” Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) “Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн хүрээнд автобус нийлүүлэх НХААГ-21/015 дугаартай гэрээний дагуу 60 ширхэг их багтаамжийн автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг цахилгаан автобус нийт 71 автобусыг тус газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн А/51 дугаартай ажлын хэсэг хүлээн авч 2022

оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар үйлчилгээнд ажиллуулж эхлээд байна.

**Хэрэгжилтийн хувь: 100**

1.2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ:

**Тусгагдсан зорилт:** 6.3.13.Сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний шинэ менежмент нэвтрүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Сурагчийн автобусны парк шинэчлэлт хийнэ.” ажлын хүрээнд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Моннис Моторс” ХХК -тай байгуулсан 2022 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу “Моннис моторс” ХХК-аас 2022 онд хүүхдийн сургуулийн 70 ширхэг автобус нийлүүлэхээс 20 ширхэг автобусыг оруулж ирсэн. Дээрх 20 автобусыг хүлээлцүүлэхээр тус газрын даргын А/41 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.Үүний дагуу тус газарт Моннис моторс ХХК-аас 2022.05.23-ний өдрийн АБ-02/272 дугаартай албан бичиг ирүүлж, 2022.05.24-ний өдөр “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т хүлээлцүүлэв. 2022 оны 06 дугаар сарын 30-ний дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас ирэх дараагийн 50 автобустай хамт өмнөх 25 автобусны хүүхдийн цүнх, тээшний тавиурыг авч ирж суурилуулахаар болсон.

**Хэрэгжилтийн хувь: 80**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулах” ажлын хүрээнд:

-2021-2022 оны хичээлийн жилд 16 долоо хоногийн хугацаанд /2022.02.14-2022.06.10-ний өдрийн хооронд/ 22 сургуулийн давхардсан тоогоор өглөө 102039, өдөр 119423, орой 86289 нийт 307772 сурагчдыг гэр, сургуулийн хооронд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 9 аж ахуйн нэгж, байгууллагын 26 тээврийн хэрэгслээр 26 чиглэлд “Сургуулийн автобус”-аар тээвэрлэсэн.

**Хэрэгжилтийн хувь: 70**

**Тусгагдсан зорилт:** 6.3.14. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулна.” ажлын хүрээнд:

- Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг нийтийн тээврийн хэрэгслийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ний өдөр нийтийн тээврийн парк шинэчлэлт, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн бодлогын хүрээнд цахилгаан хөдөлгүүртэй автобус нэвтрүүлэх чиглэлээр тооцоо, судалгаа хийж, санал боловсруулах “Ажлын хэсэг байгуулах тухай” А/190 дүгээр захирамжаар

байгуулагдсан ажлын хэсэгт нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний 25 зогсоол орчим цахилгаан автобус цэнэглэх цэг байгуулах схем зураг бүхий саналыг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д 2022 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 2/253 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Дээрх саналын хүрээнд цахилгаан автобусыг цэнэглэх цэгийн газрын байршил, цахилгаан эх үүсвэр, зэрэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг холбогдох мэргэжлийн байгууллагууд болон Зорчигч Тээврийн Нэгтгэл ОНӨААТҮГ, Зорчигч Тээвэр Гурав ОНӨААТҮГ судлах ажлыг хийж байна.

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ нь СБД-ийн 16-р хороо Тоосгоны эцсийн автобусны зогсоол, 20-р хороо Сэлбийн автобусны эцсийн зогсоол, Налайх дүүргийн 2-р хорооны автобусны эцсийн зогсоолд нийт 3 цэгт 0.4 КВА хүчдэл өргөх ЦТП-г угсарч цахилгаан автобус цэнэглэх станцыг бүрэн ашиглалтад оруулаад байна.

**Хэрэгжилтийн хувь: 30**



*Цахилгаан автобус цэнэглэх цэг*

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.” ажлын хүрээнд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Сүлдэрхан минералс” ХХК болон “Xia men golden dragon bus” Co.,Ltd хооронд 2021 оны 10 дугаар сарын 27-ний өдөр байгуулсан “Зам, тээврийн хөгжийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн НХААГ-21/015 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх олон улсын стандартын шаардлага хангасан Евро-5 хөдөлгүүртэй БНХАУ-д үйлдвэрлэсэн XIAMEN GOLDEN DRAGON BUS XML6105J15C загварын их багтаамжийн 60 автобусыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдөр хүлээлцүүлж нийтийн тээврийн үйлчилгээнд 2022 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн үйлчилгээнд явж эхлээд байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 6 дугаар сард 35 их багтаамжийн автобус, 2022 онд 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг их багтаамжийн нийт 46 цахилгаан хөдөлгүүртэй автобус авч нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллуулж байна.

**Хэрэгжилтийн хувь: 90**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хотын такси тээврийг хөгжүүлж, менежментийг сайжруулна.” ажлын хүрээнд:

- Тайлбар: Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Эрх шилжүүлэх тухай” А/202 дугаар захирамжаар Улаанбаатар хотын такси үйлчилгээг хөгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнг танилцуулж ажиллахыг “Улаанбаатар хотын хөгжлийн корпорацад” даалгасан боловч тодорхой ажил хийгдээгүй. 2018-2019 он дамжин санхүүжигдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад “Улаанбаатар такси сервис төсөл хэрэгжүүлэх”-ээр мөн л 700,0 сая төгрөгийг баталсан боловч тодорхой ажил хийгдээгүй. 2020 онд Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” өдрийн А/889 дүгээр захирамжаар Улаанбаатар хотын такси сервис төсөл хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг баталж, уг төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Улаанбаатар такси каб ХХК-д шилжүүлсэн. 2021, 2022 онуудад он дамжин санхүүжигдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад “Улаанбаатар такси сервис төсөл хэрэгжүүлэх”-ээр мөн л 700,0 сая, 670,0 сая төгрөгийг баталсан байна. Төсөв нь тус газраас хараат бус байгаагаас арга хэмжээ авч хариуцан ажиллаж, гүйцэтгэл гаргах боломжгүй байна. 2022 оны 05-р сарын 30-ний өдөр Улаанбаатар хөгжлийн корпорац ХК-д төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хийгдэж буй ажил, цаашид хотын такси тээврийг хөгжүүлэх талаар байгууллагын зүгээс хийхээр төлөвлөж буй ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх тухай 3/690 тоот албан бичиг хүргүүлсэн.

**Хэрэгжилтийн хувь: 30**

**Тусгагдсан зорилт:** 6.3.15. Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Агаарын дүүжин замын тээврийн төсөл”-ийг хэрэгжүүлнэ. ажлын хүрээнд:

- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн А/900 дугаар захирамжаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан. Дээрх захирамжийн хүрээнд “Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ”, “Дүүжин тээврийн төслийн Баянхошуу, Ханын материал, Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажилд нээлттэй сонгон шалгаруулалт явагдаж “Максимал” ХХК болон “Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн” ТББ-ын хамтарсан баг шалгарч 2022 оны 03 дугаар сарын 16-ний өдөр “Дүүжин тээврийн төслийн Баянхошуу, Ханын материал, Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа”-ний эхлэлийн болон дундын тайланг ирүүлээд байна. Тус ажлын хүрээнд Нийтийн Тээврийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/42 дугаар тушаалаар “Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих” үүрэг бүхий 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг нь 2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр хуралдаж зөвлөх үйлчилгээний эхлэлийн болон дундын тайлантай танилцаж гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн хянаж Нийслэлийн Засаг даргын тамгын газарт

2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 2/566 дугаартай албан бичгээр гүйцэтгэлийн актыг хүргүүлээд байна.

Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд дүүжин тээврийн үйлчилгээг 4 чиглэлд трасс төлөвлөлтийн шийдлийг боловсруулсан. 2020 онд дүүжин тээврийн хэрэгжүүлэлтийн өмнөх захиргааны судалгаагаар Хувилбар 1, Хувилбар 3, Хувилбар 4-1 - ийг боловсруулсан бол, бидний судалгааны баг хувилбар 2, хувилбар 4-2 - ийг трасс төлөвлөлтийн хувилбарыг боловсруулсан.



Трасс төлөвлөлтийн хувилбар

**Хэрэгжилтийн хувь: 40**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Өндөр хүчин чадалтай нийтийн тээврийн төслийг хэрэгжүүлнэ.” ажлын хүрээнд:

- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн А/900 дугаар захирамжаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан. Дээрх захирамжийн хүрээнд “Тулгуурт гүүрэн

байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажилд нээлттэй сонгон шалгаруулалт явагдаж “Максимал” ХХК болон “Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн” ТББ-ын хамтарсан баг шалгарч 2022.03.16-ний өдөр эхлэлийн тайланг ирүүлээд байна. Тус ажлын хүрээнд Нийтийн Тээврийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/42 дугаар тушаалаар “Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих” үүрэг бүхий 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг нь 2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр хуралдаж зөвлөх үйлчилгээний эхлэлийн болон дундын тайлантай танилцаж гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн хянаж Нийслэлийн Засаг даргын Тамгийн газарт 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 2/565 дугаартай албан бичгээр гүйцэтгэлийн актыг хүргүүлсэн. ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.

**Хэрэгжилтийн хувь: 40**

**Тусгагдсан зорилт:** 6.3.16. Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.” ажлын хүрээнд:

1. Нийслэлийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн А/259 дүгээр захирамжийн авто замын түгжрэлийг бууруулах төсөл нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргад шилжүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн А/259 дүгээр захирамжаар 2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулахлаар төлөвлөгдсөний дагуу тохижуулах зогсоолын саналыг 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдөр 2/233 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.

2.УИХ-н гишүүн Ц.Мөнх-оргилын санаачилгаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах нийтийн тээврийн хэрэгслийн 15 дундын болон 2 эцсийн зогсоолын шинэчлэл тохижилтын ажил хийгдэж байна.

3.УИХ гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачилгаар Зам тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянган чиглэлд нийтийн тээврийн автобусны 19 зогсоолын тохижилт хийгдэж байна.

4.Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Чингэлтэй дүүргийн 17, 18-р хороонд хийгдэх Чингэлтэй 5.1 км авто замд 19 автобусны зогсоол тохижуулах бөгөөд 2 зогсоол нь битүү бүхээгтэй эцсийн зогсоол дундын 17 автобусны зогсоолыг тохижуулах ажил хийгдэж байна.

5.Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2021 онд хийгдэх автобусны дундын зогсоолыг 3 багц болгон хувааж гүйцэтгэсэн бөгөөд 1 багц ажлын тендер нь 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр явагдаж “Өргөн говь” ХХК шалгарч

Баянзүрх дүүрэг Их хүрээний зам дагуу Мандал хотхоны /хойд урд/ мөн Чингэлтэй дүүрэг Хайлаастын зам /хойд/ Хайлаастын завсрын автобусны зогсоолыг ажлыг хийж байна.

**Хэрэгжилтийн хувь: 40**

**Тусгагдсан зорилт:** 6.3.18. Ачаа тээврийн удирдлагын системийн нэмэлт хөгжүүлэлтийн программ хангамж боловсруулж, ачаа тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг үе шаттайгаар шөнийн горимд шилжүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Ачаа тээврийн шөнийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, менежментийг сайжруулна.” ажлын хүрээнд:

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102-р тогтоолоор баталсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ийг хэрэгжүүлэх явцад ачаа тээвэрлэлтээр зайлшгүй зохион байгуулах ажлуудыг нэмж оруулах шаардлага үүсэж, шинэчилсэн төслийг боловсруулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барихаар Нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2022 оны 05 дугаар сарын 16-ний өдөр 4/587 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Дээрх журмын төсөлд 5.2.7, 6.1.1, 6.1.2, 6.1.3 -т ачаа тээврийн шөнийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүнс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний түгээлтийг авто замын хөдөлгөөний ачаалал багатай цагуудад тээвэрлэхээр зохион байгуулахаар тусгаж оруулсан.

Журмаа Засаг даргын зөвлөлийн хуралд оруулахаар Нийслэлийн тамгын газрын хэлтсүүдээс санал авах байна.

**Хэрэгжилтийн хувь: 30**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Ачааны автомашины ЕС түр зөвшөөрлийн програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлнэ.” ажлын хүрээнд:

- Ачааны автомашины ЕС түр зөвшөөрлийн программ хангамжийн ажил бүрэн хийгдэж, хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Мөн Зам Тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран дотоодын ачаа тээврийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх талаар 2022 оны 06 дугаар сарын 13-ний өдөр хуралдсан. Дээрх хуралд улсын хэмжээний ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхээр ачаа тээврийн мэдээллийг авахаар платформ үүсгэж байгаа бөгөөд уг платформд олон улсын ачаа тээвэр, хот хоорондын, хотын доторх гэж тус тусад нь байршуулахаар Нийслэл дотор ачаа тээвэрлэлтийн программ хангамжаа хөгжүүлэхээр шийдвэрлэсэн.

**Хэрэгжилтийн хувь: 100**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан”-ийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлнэ.” ажлын хүрээнд:

-"Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-ийн программ хангамжийн санхүүжилтийг шийдвэрлэж, программын хангамжийн гүйцэтгэл 80 хувьтай хийгдсэн.

Тайлбар: Авто үйлчилгээний программ хангамжийг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын серверт байршуулахаар болсон.

Сервер нь cpu:4, ram:8gb,hdd:250gb үзүүлэлттэй бөгөөд уг серверт байршуулах бэлтгэл ажлуудыг 06 сарын 09 өдөр хийж дууссан.

Программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэхэд сервер болон сүлжээнд тохиргоонуудыг хийх шаардлага тулгараад байна.

**Хэрэгжилтийн хувь: 70**

Хүсэлтэн дугаар	Төлөв	Үйлчилгээний газрын нэр	Удирдлагын нэр	Хүсэл гаргагч нь	Хаанаас	Үүссэн огноо	Үйлдэл
20620776	Үүссэн				E-mongolia	2022-06-20 09:54:52	
20620780	Үүссэн				E-mongolia	2022-06-20 09:41:09	
20620796	Үүссэн				E-mongolia	2022-06-20 09:33:11	

Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сангийн программ

**Тусгагдсан зорилт:** 6.3.19. Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл, хяналт, зохицуулалтын удирдлагын төв байгуулна.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Удирдлагын төвд хяналтын дэлгэц байршуулж, нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд зорчигч тоолох систем суурилуулж, бүртгэл мэдээллийн программ хангамж нэвтрүүлнэ.” ажлын хүрээнд:

- Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/126 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хангуулах холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлэх ажлын саналыг тусгасан. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн А/491 дүгээр захирамжаар “Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусламжтайгаар сайжруулах, “Зам тээврийн ухаалаг нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа тооцоог гаргах техникийн даалгавруудыг нэгтгэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт санал тусган ажилласан. Зам тээврийн ухаалаг систем нэвтрүүлэхэд шаардлагатай нийслэлийн

гол замын 161 уулзварт RFID уншигч байрлуулах байршлын судалгаа хийгдэж байна. Нийтийн тээврийн 122 автобусанд RFID Уншигч байршуулан судалгаа хийж байна.

**Хэрэгжилтийн хувь: 30**

1.3. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧТАЙ 2021-2024 ОНД ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ:

**Тусгагдсан зорилт:** Хоёр. Байгаль орчинд ээлтэй, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлж, Улаанбаатар хотын зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудлуудыг бий болгох, ачаа тээврийн нэгдсэн логистикийг хөгжүүлэх.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлтийг хийх.” ажлын хүрээнд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Сүлдэрхан минералс ХХК болон “Xia men golden dragon bus” Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) “Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн хүрээнд автобус нийлүүлэх НХААГ-21/015 дугаартай гэрээний дагуу 60 ширхэг их багтаамжийн автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг цахилгаан автобус, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Моннис Моторс” ХХК -тай байгуулсан 2020 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус нийт 91 автобусыг тус газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн А/51 дугаартай ажлын хэсэг хүлээн авч 2022 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар үйлчилгээнд явж эхлээд байна.

**Хэрэгжилтийн хувь: 80**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Хөшгийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгоно.” ажлын хүрээнд:

-Хөшгийн хөндийн “Чингис хаан” олон улсын шинэ нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхээр тус газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн А/71 тушаалаар Экспресс:1 “Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал – Улсын их дэлгүүр-120 мянгат”, Экспресс:1 “Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал – Драгон төв” /5 ШАР/ чиглэлийг баталж 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн доорх 2 чиглэлд 3 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлэн ажиллаж байна.

**Хэрэгжилтийн хувь: 100**



- Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачааны логистик төв барих ажлын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг оновчтой зөв зохион байгуулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яам, Солонгос улсын логистик төлөвлөлтийг хийсэн Котро компани, Монгол дахь Солонгосын Элчин зэрэг байгууллагуудын хамтарсан “Монгол Улсын тээвэр, логистикийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратеги боловсруулах” техникийн туслалцааны төслийн онлайнаар зохион байгуулсан 3 шатны ажил хариуцсан мэргэжилтнүүдтэй хамт сургалтад хамрагдсан. Сургалтаар Солонгос улсын логистикийн загварыг ашиглан Улаанбаатар хотын логистик төлөвлөлт, ТЭЗҮ боловсруулахаар ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын 2020 оны А/1124 дугаартай захирамжаар “Налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журмын дагуу зохион байгуулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д үүрэг болгосон.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтсээс Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиглэл өгч бэлтгэл ажлын хүрээнд Сонгон шалгаруулалтын баримт бичгийн урьдчилсан загвар болон Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээний урьдчилсан загварыг боловсруулсан ба мэргэжлийн талуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, сонгон шалгаруулалтыг зарлаж, Туушин ХХК шалгараад байна.

“Нийслэл хотод ачаа тээврийн логистикийн төвд тавигдах стандарт”-ийг боловсруулж, хамтран ажиллах тухай 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 4/696 дугаартай албан бичгийг Хотын стандартын хяналтын газарт хүргүүлсэн.

**Хэрэгжилтийн хувь: 30**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулна.” ажлын хүрээнд:

-Их багтаамжтай зогсоол байгуулах нийт 6 байршлыг тогтоосон. Засгийн газрын 2021 оны 248 дугаар тогтоолоор “Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо” байгуулагдсан бөгөөд Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгслийг Улаанбаатар хотод нэвтрүүлж эхлэхтэй холбогдуулан эцсийн гол зангилаа буудлуудад зорчигч тээврийн терминалуудыг байгуулахаар төлөвлөн Газар зохион байгуулалтын албаны 2021, 2022 оны төлөвлөгөөнд тусгуулж, газрын асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хүргүүлэн ажиллаж байна.

**Хэрэгжилтийн хувь: 10**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Нийслэлийн Налайх дүүрэгт Улаанбаатар төмөр замыг түшиглэн олон улсын стандартад нийцсэн ачаа тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.” ажлын хүрээнд:

-Нийслэлийн засаг даргын 2020 оны А/1124 дугаартай захирамжаар “Налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журмын дагуу зохион

байгуулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д үүрэг болгосон.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтсээс Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиглэл өгч бэлтгэл ажлын хүрээнд Сонгон шалгаруулалтын баримт бичгийн урьдчилсан загвар болон Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээний урьдчилсан загварыг боловсруулсан ба мэргэжлийн талуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, сонгон шалгаруулалтыг зарлаж, Туушин ХХК шалгараад байна.

“Нийслэл хотод ачаа тээврийн логистикийн төвд тавигдах стандарт”-ийг боловсруулж, хамтран ажиллах тухай 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 4/696 дугаартай албан бичгийг Хотын стандартын хяналтын газарт хүргүүлсэн.

**Хэрэгжилтийн хувь: 10**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Агаарын дүүжин замыг тээврийн төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлнэ.” ажлын хүрээнд:

-Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн А/900 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний 7 ажлын жагсаалтыг баталсан. Дээрх ажлын хүрээнд “Дүүжин тээврийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах” ажлын сонгон шалгаруулалт явагдаж “Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн” НҮТББ, “Жоншт уул” ХХК хамтарсан түншлэл шалгарч НХААГ-21/228 тоот гэрээний дагуу эцсийн тайланг 2022 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн 135/2022 дугаар албан бичиг тус газарт ирүүлээд байна. Тус тайланд Нийтийн Тээврийн газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалаар “Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих” ажлын хэсэг ажиллаж санал шүүмж боловсруулж байна.

**Хэрэгжилтийн хувь: 70**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Такси үйлчилгээний нэгдсэн тайлангийн систем хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.” ажлын хүрээнд:

-Нийтийн тээврийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 02-р сарын 26-ний өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулсан “Төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн хүрээнд нийслэлийн таксины үйлчилгээг сайжруулах, боловсронгуй болгох талаар судалгаа хийж, санал боловсруулах” ажлын хэсэг Улаанбаатар хотын такси үйлчилгээнд ашиглаж байгаа платформыг судалж, нэгдсэн зохион байгуулалтад орох боломжийг эрэлхийлэх, “Нийтийн таксины үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5122-2013 стандартыг цаг үеийн шаардлага, техник технологийн хөгжилтэй нийцүүлэн шинэчлэх, Такси үйлчилгээ эрхлэгчид болон Такси дуудлагын үйлчилгээ эрхлэгчдийн хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, хэрэгжилтийг хангах, Салбарын хүний нөөцийн бодлогын хүрээнд таксины жолоочийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалт авах явцыг чиг үүргийн байгууллагад шилжүүлэн авах, Таксины зогсоолын төлөвлөлт, ашиглалтын

асуудлыг сайжруулах, шаардлагатай газарт зогсоол нэмж байгуулах чиглэлээр хариуцсан чиг үүргийн хүрээнд судалгаа хийж, санал солилцсон.

Тайлбар: Уг төслийн санхүүжилтийг Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Эрх шилжүүлэх тухай” А/202 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын хөгжлийн корпорацад”, 2020 онд Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” А/889 дүгээр захирамжаар Улаанбаатар такси каб ХХК-д эрхийг шилжүүлсэн.

2022 оны 05 дугаар сарын 27-ний өдөр ЗТХЯ, Европын сэргээн босголтын банк, Таксины үйлчилгээ эрхлэгч УБТТС ХХК, тус газрын хамтарсан уулзалтыг зохион байгуулж хөнгөлөлттэй зээлээр таксины парк шинэчлэлт хийх талаар мэдээлэл солилцсон хамтран ажиллахаар болсон.

Такси үйлчилгээний нэгдсэн тайлангийн систем нэвтрүүлэх талаар судалж байна.

### **Хэрэгжилтийн хувь: 30**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Хот болон хот орчмын тээвэрлэгдэж байгаа ачаа тээврийн үйлчилгээг бүртгэлжүүлэх, хяналтыг хэрэгжүүлэх үүднээс “Тээврийн удирдлагын нэгдсэн систем” буюу [www.teeverzuuch.mn](http://www.teeverzuuch.mn) программ хангамжийг ашиглан ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн мэдээлэл болон ачаа тээврийн гүйцэтгэлийн мэдээллийг тухай бүр оруулах, шинэчлэх, мэдээллийн найдварт болон аюулгүй байдлыг хангах чиглэлээр Авто тээврийн төв болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулах.” ажлын хүрээнд:

- Ачааны автомашины нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх “ЕС” зөвшөөрлийг төрийн үйлчилгээний цахим машинаар дамжуулан цахимаар олгож байна. Ачаа тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн тайланг программ хангамж ашиглан гаргадаг.

1.“ЕС” зөвшөөрлийн хяналт, удирдлагын системийн хөгжүүлэлтэд Нийслэлийн төсвөөс 36.930.000 төгрөгийг зарцуулан Аствишн ХХК хийлгэсэн. Программын ажил 95% тай байна.

“ЕС” зөвшөөрлийн программыг Тээврийн нэгдсэн удирдлагын нэгдсэн систем буюу [www.teeverzuuch.mn](http://www.teeverzuuch.mn) программтай холбох талаар уулзалт Зам, тээврийн хөгжлийн яамнаас онлайнаар зохион байгуулж “ЕС” зөвшөөрлийн программыг Тээврийн нэгдсэн удирдлагын нэгдсэн систем буюу [www.teeverzuuch.mn](http://www.teeverzuuch.mn) программтай холбох шаардлагагүй гэж үзсэн.

“ЕС” зөвшөөрлийн хяналт, удирдлагын систем” программ хангамжийн ажил бүрэн хийгдэж дууссан ба 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай туршилт хийсэн.

Туршилтаар дээрх программд сайжруулалт хийх шаардлагатай гэж үзээд холбогдох саналаа Аствишн ХХК-д хүргүүлээд байна.

2.Түр зөвшөөрөл олгогдсон тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг [www.smartcar.mn](http://www.smartcar.mn) цахим системд холбох, замналын дагуу хөдөлгөөнд оролцож байгаа байдлыг “RFID” камерын системийг ашиглан хяналт тавих зорилгоор Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газартай уулзалт зохион байгуулж, хамтран ажиллахаар 2022 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 4/348 дугаартай албан бичгийг маягтын хамт хүргүүлсэн.

Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газраас "Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем"-ийн хөгжүүлэлтийн техникийн даалгаварт тусгах боломжтой талаар 2022 оны 04 дүгээр сарын 04-ний 01/153 дугаартай албан бичгээр хариу ирүүлсний дагуу ажлын даалгавраа төлөвлөн ажиллаж байна.

**Хэрэгжилтийн хувь: 90**

**Тусгагдсан зорилт:** Гурав. Нийслэлийн авто замын сангийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, авто зам ашигласны төлбөр, хураамжийн зохистой хэмжээг тогтоох, авто замын ашиглалт, арчлалтын байдалд тавих, хяналтыг сайжруулах.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** "Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ." ажлын хүрээнд:

- Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газарт шинээр удирдлагын төв байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж холбогдох байгууллагуудад танилцуулан хяналтын дэлгэц, техник, тоног төхөөрөмжийн жагсаалт, үнийн судалгаа гарган хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд өөрийн хяналтын систем бий болгохоор "Гранд Ай Ти ХХК"-тай "Нийтийн тээврийн үйлчилгээний ажлын нэгдсэн гүйцэтгэлтэй холбоотой үйл ажиллагааны процессыг судалж, архитектур зохиомжийг гаргаж, программ хангамжийг хөгжүүлэх", "Dashboard хяналтын самбар зохион байгуулах" гэрээ байгуулан 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр программ хангамжийн гүйцэтгэлийг "АКТ" үйлдэн хүлээн авснаар үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр Улаанбаатар смарт карт ХХК-аас шаардлагатай мэдээллийн урсгалыг авч "Нийслэлийн Дата төвд байршуулах" ажлын хэсэг байгуулагдан тус газраас төлөөлөл ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/126 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 171 дүгээр тогтоолоор баталсан "Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хангуулах холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлэх ажлын саналыг тусгасан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн А/491 дүгээр захирамжаар "Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусламжтайгаар сайжруулах, "Зам тээврийн ухаалаг нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа тооцоог гаргах техникийн даалгавруудыг нэгтгэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт санал тусган ажилласан.

Зам тээврийн ухаалаг систем нэвтрүүлэхэд шаардлагатай нийслэлийн гол замын 161 уулзварт RFID уншигч байрлуулах байршлын судалгаа хийгдэж байна. Нийтийн тээврийн 122 автобусанд RFID Уншигч байршуулан судалгаа хийж байна.

**Хэрэгжилтийн хувь: 50**

**Тусгагдсан зорилт:** Тав. Зам, тээврийн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг үр дагаврыг бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулах, устгах тогтолцоог хөгжүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, хамтарсан шалгалтыг тогтмол хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.” ажлын хүрээнд:

-Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн нийтийн тээврийн газартай хамтран ажиллах 2022 оны төлөвлөгөөг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн нийтийн тээврийн газар, Баянзүрх дүүргийн тамгын газрын хамтран баталсан 38-07-014/02 дугаартай “Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа авто үйлчилгээний байгууллагад зөвлөн туслах үйлчилгээний удирдамж”-ийн дагуу Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах талаар хууль, эрх зүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Зөвлөн туслах үйлчилгээг Зам тээврийн хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн Авто үйлчилгээ, техникийн үзлэгийн хяналт хариуцсан мэргэжилтэн, авто тээврийн хяналтын улсын байцаагч Ц.Санчирдорж ахалж, Зорчигч тээврийн хяналт хариуцсан шинжээч, Авто тээврийн хяналтын улсын байцаагч Э.Оюунтунгалаг, Зам, тээврийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн Я.Ганцэцэг, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Авто тээврийн хяналтын улсын (ахлах) байцаагч Ц.Хадбаатар, У.Энхтөр, Нийслэлийн нийтийн тээврийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн Авто тээврийн хяналтын улсын байцаагч Ш.Бямба, Логистикийн хэлтсийн авто үйлчилгээ хариуцсан ажилтан С.Билгүүн, Г.Базарсад, Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн Үйлдвэрлэл, инновац, авто засвар хариуцсан мэргэжилтэн А.Ууганбаатар нар 2022 оны 04 дүгээр сарын 13-наас 04 дүгээр сарын 29-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Зөвлөн туслах үйлчилгээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч нийт 96 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдлаа. Үүнээс авто үйлчилгээ эрхлэгч 24 аж ахуйн нэгж, байгууллага, 72 иргэн хамрагдсан ба үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл агрегат засвар-82, кузов засвар-14 байна.

Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан нийт 96 авто үйлчилгээ эрхлэгчдээс ангиллаа тогтоолгосон 7 авто үйлчилгээ эрхлэгч буюу 7,2%, тохирлын үнэлгээнд хамрагдсан 11,4% байна.

“Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа авто үйлчилгээний байгууллагад зөвлөн туслах үйлчилгээний удирдамж”-ийн дагуу нийт 96 авто үйлчилгээ эрхлэгчдийн үнэлэх боломжтой 17 байгууллага, иргэний үйл ажиллагаанд үнэлгээ өгч, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн эрсдэлийг бууруулах талаар хууль эрх зүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

## **Хэрэгжилтийн хувь: 100**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Авто үйлчилгээний салбараас үүсэж буй хог хаягдлыг авто үйлчилгээ эрхлэгчдээс боловсруулах үйлдвэр хүртэлх тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээ бий болгох.” ажлын хүрээнд:

- Нийтийн тээврийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ний өдрийн “Авто үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад холбогдох хууль эрх зүйн мэдлэг олгох” сургалтын удирдамж батлагдсаны дагуу Сүхбаатар, Хан-Уул, Багануур, Баянгол дүүргүүдэд Зам, тээврийн хөгжлийн яам, Дүүргүүдийн онцгой байдлын газар, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ, Дүүргүүдийн засаг даргын тамгын газартай хамтран сургалт зохион байгуулан ажилласан.

Сургалтад 4 дүүргийн хэмжээд бүртгэлтэй 529 авто үйлчилгээ эрхлэгчдээс нийт 92 иргэн, аж ахуйн нэгж байгууллага буюу 17.3% нь хамрагдсан. Үүнээс Багануур дүүрэгт бүртгэлтэй 32 авто үйлчилгээ эрхлэгчдээс 20 авто үйлчилгээ эрхлэгчид /62.5%/, Сүхбаатар дүүрэгт бүртгэлтэй 133 авто үйлчилгээ эрхлэгчдийн 21 авто үйлчилгээ эрхлэгчид /13.3%/, Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй 94 авто үйлчилгээ эрхлэгчдээс 15 авто үйлчилгээ эрхлэгчид /15.9%/, Баянгол дүүрэгт бүртгэлтэй 270 авто үйлчилгээ эрхлэгчдээс 36 авто үйлчилгээ эрхлэгчид /13,3%/ байна.

Дээрх сургалтад хамрагдсан авто үйлчилгээ эрхлэгч 56 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авто үйлчилгээний салбараас үүсэж буй хог хаягдлын судалгаа авч нэгтгэн ажилласан.

Нийслэл хотод авто тээврийн хэрэгслээс гарсан ажилласан масло, тос, хуучин дугуйг дахин боловсруулах үйлдвэрийн хүчин чадал хангалтгүй байгаагаас авто үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын хог хаягдлын асуудлыг шийдвэрлүүлэхэд хүндрэл гарч байна.

Авто үйлчилгээний байгууллагаас гарч буй хог хаягдлын судалгааг сургалтад хамрагдсан 92 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас авч нэгтгэн ажиллалаа. Судалгаагаар сард дунджаар Багануур дүүрэгт-1.9 тонн, Баянгол дүүрэгт-0, Сүхбаатарт дүүрэгт-10.6 тонн, Хан-Уул дүүрэгт-0.7 тонн хог хаягдал үүсэж байна. Нийт хог хаягдлын 10.5 мянган тонн буюу 67.7 хувь нь хатуу хог хаягдал, 5 мянган тонн буюу 32.3 хувь шингэн хог хаягдал үүсэж байна.

Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хог хаягдлыг шингэн, хатуу, аюултай гэсэн нэр төрлөөр ялган 1 сард дунджаар нийт 13,4 тонн хог хаягдал гарч байна.

## **Хэрэгжилтийн хувь: 40**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Аюултай ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааны хяналт, бүртгэлийн тогтолцоог сайжруулах.” ажлын хүрээнд:

- Нийслэлийн ачаа тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ийг хэрэгжүүлэн, ачаа эргэлт болон тээвэрлэлтийн тоон мэдээ гаргаж, мэдээллийн санг баяжуулж ажилласан.

2022 оны эхний улирлын байдлаар аюултай ачаа тээвэрлэгч 57 аж ахуйн нэгж, байгууллагын 1126 тээврийн хэрэгсэлд “ЕС” зөвшөөрөл, 172 тээврийн хэрэгсэлд “ТҮР” зөвшөөрлийг олгосон.

“Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ийн шинэчилсэн төсөлд аюултай ачаа тээвэрлэж буй авто тээврийн хэрэгсэлд тус газрын авто тээврийн хяналтын улсын байцаагч “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 4978:2017 стандартын дагуу тээвэрлэлтийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гарган бүртгэлийн сан үүсгэн, хяналт тавих талаар тусгасан бөгөөд уг төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барихаар Нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2022 оны 05 дугаар сарын 16-ний өдөр 4/587 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

2022 онд зөвшөөрөл авсан аюултай ачаа тээвэрлэх аж ахуйн нэгжийн (өөрийн эзэмшлийн болон гэрээ байгуулан ажилладаг) тээврийн хэрэгслийн судалгааг Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 4/242 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

**Хэрэгжилтийн хувь: 90**

## ХОЁРДУГААР БҮЛЭГ:ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 2.1. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ:

Монгол улсын Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн болон Тэргүүлэгчдийн тогтоол, хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нийслэлийн тээврийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг хяналтад авч, биелэлтийг <https://monitoring.ulaanbaatar.mn/> программаар тухай бүрд тайлагнан ажилласан.

### Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт (дэлгэрэнгүй)

Эхлэх огноо: 2022-07-01  
Дуусах огноо: 2022-07-31  
Биелэлтийн дүн: 63.11%

Нийт захирамж: 7  
Холбогдох заалт: 20  
Гүйцэтгэсэн захирамж: 7 (63.11%)  
Гүйцэтгээгүй захирамж: 0 (0%)

Захирамжлалын баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Дугаар	Гүйцэтгэлийн тоо	Төрөл	Хэвсрэлт файл	Биелэлт			
Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай	2022-02-17	A/212	4	Нийслэлийн Засаг даргын Захирамж	A_212 NGZB_NKLBKNG_NHCG_NZKNG_NHAAAG_NTAGG_NOKNG (1).pdf	61.22			
Холбогдох заалтууд		Хариуцагч		Биелэлтийг мэдээлэх хугацаа		Гүйцэтгэлийн тоо			
1. Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад уураг болгосугай. 1.1 мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүхий л үе шатанд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгуулалтын удирдлагад.		Нийт байгууллага: 100%		2022-03-25 2022-06-25 2022-09-25 2022-12-25		4			
Гүйцэтгэгч	Гүйцэтгэл тоо	Огноо	Гүйцэтгэл	Гүйцэтгэл төрөл	Гүйцэтгэл хувь	Үнэлсэн огноо	Үнэлгээ	Үнэлгээ хувь	Төлөө
Нийтийн тээврийн газар	2	2022-03-25	Нийтийн тээврийн газрын дагын 2022.03.09-ний өдрийн А/20 дугаар тушаалаар "Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЗУ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих" уураг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хэрэгжиж буй төсөл арга хэмжээний ажилд захирагчийн хяналт тавьж ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлж байгаа "Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн", "Максимал" ХХК-аас дараах төслийн эхлэлийн тайланг ирүүлээд байна. Үүнд: 1. "Нийтийн тээврийн зорчих тасалбарын төлбөр болон нийтийн	Хэрэгжиж шатаанд	30	2022-05-25	Хүлээн авлаа	30	Тооцос

<https://monitoring.ulaanbaatar.mn/> программаар тайлагнасан байдал.

2022 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн нийт 15 удаа хуралдаж, шуурхайгаас өгсөн нийт 78 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр <https://backend.ulaanbaatar.mn/> цахим системд тайлагнан ажилласан. Нийт 78 үүрэг даалгаврын хэрэгжилтийн дундаж 95 хувьтай байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

### **3.1. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжаар батлагдсан тус газрын “Дүрэм”-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг эхний хагас жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн.

#### **3.1.1. Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийн үйл ажиллагааны хүрээнд:**

Шинэ замын төлөвлөлт, замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын зурагт нийтийн тээврийн үйлчилгээний зориулалтын автобусны зогсоол байгуулах, байршлыг өөрчлөх тухай санал тусгуулах ажлын хүрээнд:


Шинэ замын төлөвлөлт, замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын дараах зураг төслүүдэд санал өгч батлуулсан. Үүнд:

1. Нийслэлийн авто замын хөгжлийн газрын захиалгаар, Кадсүрвэй ХХК-ны хийж гүйцэтгэж байгаа (Сүхбаатар дүүрэг, 19-р хороо)-ны “Гоодойн авто замаас Шаргаморьтын авто замтай холбогдох 1786.6 метр хатуу хучилттай авто зам,
2. Улаанхуарангийн авто замаас хойшоо 10 дугаар байр хүртэлх шинээр хийгдэх авто зам (Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо)- ны авто зам Худгийн гудамжийг Цагдаагийн гудамжтай холбох авто зам,
3. Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хорооны авто зам,
4. Голден Вилл хотхоноос урагш шинээр баригдах Сэлбэ голын далан дагасан авто зам /Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо/- ны авто зам,
5. 53 дугаар сургууль орчим шинээр баригдах авто зам Баянзүрх дүүрэг, 16 дугаар хорооны авто зам,
6. Токио таун хотхоны зүүн талаар Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замыг Жапан тауны авто замтай холбох авто зам (Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо)-ны авто зам,
7. "UB Town" хотхоны зүүн талаас Туул гол хүртэлх авто зам (Хан-Уул дүүрэг, 19 дүгээр хороо)- ны авто зам,
8. Ерөнхий боловсролын Шинэ Зууны Билэг дунд сургуулийн баруун талаас Туул гол хүртэлх авто зам (Хан-Уул дүүрэг, 19 дүгээр хороо)-ны авто зам,

9. Баянгол дүүргийн 8 дугаар хороонд баригдах Чингүүнжавын Гудамжнаас баруун тийш Гэмтлийн эмнэлгийн урдуур Ард Аюушийн өргөн чөлөө хүртэлх “Ангад Арвижих” ХХК-ны авто зам,
  10. Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа” – ХХК-ны Улаанхуарангийн авто замаас Улиастайн замтай холбогдох зам,
  11. Нийслэлийн авто замын хөгжлийн захиалгаар “Жи Ар Си” ХХК-ний Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо Гэрэлт Өргөө хотхоны баруун талаар Үйлдвэрийн гудамжийг Ноолуурын гудамжтай холбох авто зам
- Хүрсэн үр дүн:** Шинээр тавигдах авто замуудад нийтийн тээврийн автобусны 56 зогсоолыг шинээр стандартын дагуу байгуулахаар саналаа тусгуулсан.

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс чиглэл, зогсоол өөрчлөх, нээх, хаах талаар холбогдох судалгаа хийж, төлөвлөлтийн санал боловсруулж танилцуулж, шийдвэрлүүлэх ажлын хүрээнд:


Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг ойртуулах зорилгоор дараах Ч:57Б "Алтан овоо - Улаанчулуут - Их наран - МУИС", Ч:18А "3,4 хороолол - 6-р Бичил хороолол - Ард кино театр - ТЭЦ 3" төв, Ч:18Б "3,4 хороолол - 6-р Бичил хороолол - ТЭЦ 3 - Цэцэг төв" чиглэлүүдэд өөрчлөлт оруулж, тус газрын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/12 дугаар батлуулж, үйлчилгээг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс үйлчилгээг эхлүүлсэн.



Шинээр тавигдсан авто замын зураглал /Google Earth/



Чиглэлийн зураглал




Өөрчлөлт орж буй авто замын зураглал /Google Earth/



Чиглэлийн зураглал

Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг ойртуулах зорилгоор Ч:62 “Алтан овоо 42-р гудамж /СХД 36-р хороо/-Саппоро-10-р хороолол” чиглэлийг Алтан овоо 48 дугаар гудамж хүртэл 2.2 км сунгаж Ч:62 “Алтан овоо-Саппоро-10-р хороолол” болгон өөрчилж тус газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар батлуулж, үйлчилгээг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлэх шийдвэр гарсан.




Өөрчлөлт орж буй авто замын зураглал /Google Earth/



Чиглэлийн зураглал

Мөн Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх Зүүн салаа, Баянхошууг холбосон 1 км шинэ авто замаар нийтийн тээврийн үйлчилгээний Ч:48А “Зүүн салаа-Шинэ зам /хойгуур/-Чингэлтэй дүүрэг-МУБИС” чиглэлийг шинээр нээж, тус газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлуулж, үйлчилгээг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлэх шийдвэр гарсан.



Шинээр тавигдсан авто замын зураглал /Google Earth/



Чиглэлийн зураглал

**Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолын тохижилтын ажлын хүрээнд:**

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй Чингэлтэй дүүргийн 17,18-р хороонд “Гэр хороололд тээврийн үйлчилгээг сайжруулах” жишиг төслийн хүрээнд Чингэлтэйн амны автобусны 16 зогсоолыг тохижуулахаар 2020 оноос төсөл хэрэгжүүлж байна. Тус газраас уг ажлын хүрээнд “Аркетайп Монголиа” ХХК-ийн боловсруулсан зураг төслийн дагуу автобусны зогсоолуудын тохижилтын ажил хийгдэж байна.



**Нийтийн тээврийн зогсоолуудыг кадастаржуулах ажлын хүрээнд:**

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Гэр хороололд нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах” МОН52374 төслийн хүрээнд Чингэлтэйн гудамжны эцсийн зогсоол болон Сэлбэ дэд төвийн Бизнес инкубаторын барилгын дэргэдэх зогсоолын газрын гэрчилгээг гаргуулж бүртгэлжүүлээд байна.



**Хотын авто зам засварын шинэчлэлт, өргөтгөлийн ажлын төлөвлөгөөний дагуу зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тухай бүрд төлөвлөж зохион байгуулах ажлын хүрээнд:**

СБД-ийн 6-р хороо “Их сургуулийн гудамж”-ний авто зам, Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвараас Өлзий төвийн уулзвар хүртэлх авто замыг хэсэгчлэн хаасантай холбогдуулан нийтийн тээврийн 9 чиглэлийн замналд өөрчлөлт оруулж зураглалыг зурж иргэд аж ахуйн нэгж байгууллагыг мэдээллээр ханган ажилласан.

СБД-ийн 6-р хороо "Их сургуулийн гудамж"-ны авто зам, Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвараас  
Өлзий төвийн уулзвар хүртэлх хэсгийг хаах үеийн зураглал



*Зам хаагдах үеийн нийтийн тээврийн чиглэлийн төлөвлөлт*

**Хүрсэн үр дүн:** Зам засварын үеэрх нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн, жигд ажиллагааг ханган иргэдэд үйлчилгээг хүргэж ажилласан.

*Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйлчилгээний цаг рейсийн нэгдсэн даалгаврыг сар бүр боловсруулах талаар:*

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын шугамын цаг, рейсийн нэгдсэн даалгаврыг сар бүр боловсруулан батлуулж холбогдох хэлтэс, "Улаанбаатар Смарт карт" ХХК-д цаасан хэлбэрээр өгч ажилласан. Тайлант хугацаанд 29 удаа нэгдсэн даалгаварт өөрчлөлт орсон байна.

**Хүрсэн үр дүн :** Иргэдийн санал хүсэлтийн дагуу зохих судалгаа хийж график, төлөвлөлт боловсруулснаар иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэж үйлчилгээ сайжирсан.

*Орлогын доод хязгаарыг улирал бүрээр батлуулан мөрдүүлэх ажлын хүрээнд:*

Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн зорилтын тоон мэдээллийг үндэслэн 1 болон 2 дугаар улирлын орлогын доод хязгаарыг шинэчлэн тогтоож газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан мөрдүүлсэн.

*Салбарын техник эдийн засгийн үзүүлэлтийг гарган батлуулах ажлын хүрээнд:*

Нийтийн тээврийн салбарын 2021 оны жилийн эцсийн Техник Эдийн Засгийн үзүүлэлтийг боловсруулж Зам Тээврийн Хөгжлийн яам, Нийслэлийн Статистикийн газарт албан бичгээр хүрүүлсэн.


Нийтийн тээврийн салбарын 2022 оны 1 дүгээр улирлын Техник Эдийн Засгийн үзүүлэлтийг боловсруулж Зам Тээврийн Хөгжлийн яам, Нийслэлийн Статистикийн газарт албан бичгээр хүрүүлсэн.

### 3.1.2. Судалгаа шинжилгээний ажлын хүрээнд:

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, зогсоол, үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу Ч:18а, Ч:18Б, Ч:45, Ч:57, Ч:62, Ч:67, ХО:3, ХО:12 чиглэлүүдэд холбогдох судалгааг хийсэн.


Зорчигч урсгалын судалгааг tbox.uscc.mn программ хангамжаас нийтийн тээврийн үйлчилгээний Ч:67 "Морингийн даваа-Нисэх", ХО:14 "Жаргалант тосгон - Хархорин" чиглэлүүдийн зорчигч урсгалын судалгааг хийсэн. Ч:67 чиглэлд тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх шаардлагагүй гэж дүгнэлт гаргасан.

#### ХО:14 "ЖАРГАЛАНТ ТОСГОН - ХАРХОРИН" ЧИГЛЭЛИЙН ЗОРЧИГЧ УРСГАЛЫН СУДАЛГАА



2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 25-ны өдрүүдийн зорчигчийг цагийн үечлэлээр харуулбал:

Он.сар.өдөр	2022.02.21			2022.02.22			2022.02.23			2022.02.24			2022.02.25		
Цаг	Суусан	Буусан	Нийт	Суусан	Буусан	Нийт	Суусан	Буусан	Нийт	Суусан	Буусан	Нийт	Суусан	Буусан	Нийт
06:30~07:30	7	0	7	12	0	12	8	0	8	8	0	8	12	0	12
07:30~08:30	12	1	13	8	1	9	18	1	19	13	1	14	16	1	17
08:30~09:30	6	0	6	8	1	9	5	0	5	6	1	7	8	0	8
09:30~12:30	27	6	33	37	1	38	41	4	45	31	0	31	27	3	30
12:30~16:30	41	7	48	47	2	49	50	3	53	47	6	53	65	4	69
16:30~17:30	12	2	14	13	2	15	14	1	15	11	2	13	11	0	11
17:30~18:30	5	2	7	7	1	8	9	1	10	1	0	1	16	1	17
18:30~19:30	5	0	5	5	0	5	7	0	7	20	1	21	6	0	6
19:30~20:30	2	0	2	9	1	10	8	1	9	4	1	5	9	0	9
20:30~21:30	3	0	3	0	0	0	1	0	1	0	0	0	0	0	0
<b>Нийт</b>	<b>120</b>	<b>18</b>	<b>138</b>	<b>146</b>	<b>9</b>	<b>155</b>	<b>161</b>	<b>11</b>	<b>172</b>	<b>141</b>	<b>12</b>	<b>153</b>	<b>170</b>	<b>9</b>	<b>179</b>



Тухайн чиглэлээр өглөөний 06:30-07:30, 07:30-08:30, 09:30-12:30, өдрийн 12:30-16:30 цагуудад хамгийн их зорчигчтой байна.

### Ч:67 "МОРИНГИЙН ДАВАА-НИСЭХ" ЧИГЛЭЛИЙН ЗОРЧИГЧ УРСГАЛЫН СУДАЛГАА

Он.сар.өдөр	Гараг	Нийт зорчигчийн тоо	1 рейсийн зорчигч	Он.сар.өдөр	Гараг	Нийт зорчигчийн тоо	1 рейсийн зорчигч
2022.02.07	Даваа	322	11	2020.02.07	Баасан	327	11
2022.02.08	Мягмар	308	10	2020.02.08	Бямба	362	17
2022.02.09	Лхагва	308	10	2020.02.09	Ням	224	10
2022.02.10	Пүрэв	354	12	2020.02.10	Даваа	367	13
2022.02.11	Баасан	315	10	2020.02.11	Мягмар	338	12
2022.02.12	Бямба	315	11	2020.02.12	Лхагва	289	10
2022.02.13	Ням	315	11	2020.02.13	Пүрэв	296	10
2022.02.14	Даваа	445	15	2020.02.14	Баасан	303	11
2022.02.15	Мягмар	448	15	2020.02.15	Бямба	240	11
2022.02.16	Лхагва	450	15	2020.02.16	Ням	211	10
<b>Дундаж зорчигч</b>		<b>358</b>		<b>Дундаж зорчигч</b>		<b>295</b>	

	Амралтын өдөр
	Ажлын өдөр

Тус чиглэлд өдөрт 1 тээврийн хэрэгсэл үйлчилгээнд ажиллаж байна. 2020 онд 1 өдөрт дунджаар 295 зорчигч, 1 рейсэнд дунджаар 10-13 зорчигч, 2022 онд 1 өдөрт дунджаар 358 зорчигч, 1 рейсэнд 10-15 зорчигч зорчсон байна. 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс хичээл сургууль эхэлсэнтэй холбоотой зорчигч урсгал нэмэгдэж 1 рейсэнд 15 зорчигч зорчиж, зорчигчийн тоо өссөн байна.

Тухайн чиглэлийн зорчигч урсгалын эзлэх хувийг цагийн үечлэлээр харуулбал хамгийн их зорчигчтой цаг нь 06:30-07:30, 07:30-08:30, 12:30-16:30 цагуудад зорчигч урсгал их байна.

Цаг	Зорчигчийн хувь	Цаг
06:30-07:30	11%	1
07:30-08:30	11%	1
12:30-16:30	32%	3

Нийт тухайн чиглэлийн өглөөний 06:30-07:30, 07:30-08:30 цагийн үед Морин 10, Морин 11 зогсоолууд дээрээс хамгийн зорчигчтой бөгөөд оройны 12:30-16:30 цагийн үед Орон сууц зүүн, баруун зогсоолуудаас хамгийн зорчигчтой байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, зогсоол, үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу Ч:2, Ч:37, Ч:40, Ч:50, Ч:56, Ч:6, чиглэлийн өөрчлөлтийн талаар холбогдох судалгааг хийж, хэлтсийн даргад танилцуулан ажилласан.

Улаанбаатар хотын автозамын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах Наадамчдын авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ гаргах, тус замаар зорчих нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан "Архивын ерөнхий газар-120 мянгат" экспресс чиглэлийг шинээр нээж, өглөө оройны ачаалалтай цагуудад 7 минут тутамд цахилгаан 10 автобус өдрийн ачаалал багатай цагуудад автобусны тоог цөөрүүлэн үйлчлэх төлөвлөлтийн санал боловсруулан танилцуулсан.